

**"ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР"-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хамрах хүрээ	Зохион байгуулах байгууллага	Биелэлт
Нэг: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд”								
1.	1.1	Албан хаагчид олгох үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тогтоох;	Тухай бүр	Засгийн газраас шинэчлэн тогтоосон цалин хөлсийг олгосон байна.	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/08 дугаар тушалаар нийт төрийн захиргааны 79, төрийн үйлчилгээний 14 албан хаагчийн цалингийн санг шинэчлэн баталсан. -2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/376 дугаар тушаалаар албан хаагчдад зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан нэг өдрийн хоол, унааны зардлыг 35,000 төгрөг болгон шинэчлэн баталсан.
2.	1.2	Албан хаагчид улирлын ажлын үр дүнг үнэлж, дүгнэн мөнгөн урамшуулал олгох;	Улирал бүр	Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу “Маш сайн” үнэлэгдсэн албан хаагчид	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/150 дугаар тушаалаар “Маш сайн” үнэлэгдсэн 73 албан хаагчдад албан тушаалын 50 хувиар, “Хэвийн” үнэлэгдсэн 8 албан хаагчдад албан тушаалын 25 хувиар тус тус тооцож урамшуулал олгосон. -2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/245 дугаар тушаалаар “Маш сайн” үнэлэгдсэн 82 албан хаагчдад албан тушаалын 50 хувиар, “Хэвийн үнэлэгдсэн 1

								албан хаагчид албан тушаалын 25 хувиар тус тус тооцож урамшуулал олгосон. -2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/362 дугаар тушаалаар “Маш сайн” үнэлэгдсэн 72 албан хаагчдад албан тушаалын 50 хувиар тооцож урамшуулал олгосон. -2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/448 дугаар тушаалаар “Маш сайн” үнэлэгдсэн 68 албан хаагчдад албан тушаалын 50 хувиар тооцож урамшуулал олгосон.
3.	1.3	Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв ахиулах, шинээр олгох асуудлыг шийдвэрлэх;	Тухай бүр	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Б/19 дүгээр тушаалаар 9 албан хаагчдад дэс түшмэлийн дөтгөөр зэрэг, 5 албан хаагчид дэс түшмэлийн дэд зэрэг, 10 албан хаагчид дэс түшмэлийн дэд зэрэг, 5 албан хаагчдад дэс түшмэлийн тэргүүн зэрэг, 3 албан хаагчдад ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг олгосон. 2025 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Б/72 дугаар тушаалаар 1 албан хаагчид ахлах түшмэлийн гутгаар зэрэг, 1 албан хаагчид дэс түшмэлийн дэд зэргийг тус тус олгож, Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем”-д бүртгэн оруулсан.
4.	1.4	Төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах, Засгийн газрын болон төрийн газрын хаагчид дээд шагналд тодорхойлох, шагнал гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах;	Тухай бүр	Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын Төрийн албан хаагчид шагнал олгох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байна.	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Салбарыг хөгжүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган ажиллаж байгаа 2 албан хаагчдад “Төрийн албан тэргүүний ажилтан” тэмдэг, 25 албан хаагчдад “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, 61 албан хаагчдад Ерөнхий газрын даргын “Жуух бичиг”, 1 албан хаагчид “Хилийн төлөө медаль” тэмдгээр шагнасан.
Хоёр: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох зорилтын хүрээнд”								
5.	2.1	Албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны	Тухай бүр	Засгийн газрын 2019 оны 6 дугаар	Холбогдох хууль тогтоомж, дүрэм,	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн оношоор хүндээр өвдсөн, хагалгаанд орсон

		улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх;		тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.3.4 дэх заалтад хамаарах албан хаагчид	журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.			1 албан хаагчид 1,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.
6.	2.2	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй тохиолдолд нөхөн амруулах, мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;	Тухай бүр	Төрийн албаны тухай хуулийн 61.1.9 дэх заалтад хамаарах албан хаагчид	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Б/13 дугаар тушаалаар ээлжийн амралтын хуваарийг баталж, нийт 82 албан хаагч ээлжийн амралтаа биеэр эдэлсэн бөгөөд 13 албан хаагчийн ээлжийн амралтын тооцоог гаргасан. Мөн 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Б/138 дугаар тушаалаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 1 албан хаагчид ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн олгосон.
7.	2.3	Албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдвол буцалтгүй тусламж үзүүлэх;	Тухай бүр	Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.3 дахь заалтад хамаарах албан хаагчид	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагчийн ар гэрт гачигдал гарсан тохиолдолд буцалтгүй тусламжийг тухай бүр үзүүлсэн бөгөөд 7 албан хаагчдад 4,100,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, 19 албан хаагчдад цалинтай чөлөө, 6 албан хаагчид цалингүй чөлөө олгосон.
8.	2.4	Салбарын ахмадуудыг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	Тухай бүр	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар Цагаан сарын билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан салбарын нийт 61 албан хаагчид 3,655,000

								төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон. Мөн 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/349 дүгээр тушаалаар “Ахмадын баярын өдөр”-ийг тохиолдуулан нийт 63 албан хаагчид 3,465,000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон.
9.	2.5	Албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд хүндэтгэл үзүүлэх;	Тухай бүр	Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.1 дэх заалтад хамаарах албан хаагчид	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 албан хаагчдад 127,106,903 төгрөгний буцалтгүй тусламж олгож, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.
10.	2.6	Албан хаагч гэрлэх, хүүхэдтэй болох, хүүхэд үрчлэн авах, хурим хийхэд хүндэтгэл үзүүлэх, чөлөө олгох;	Тухай бүр	Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7.3.1.3 дахь заалтад хамаарах албан хаагчид	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Албан хаагчийн гэр бүлд шинээр хүүхэд мэндэлсэнд хүндэтгэл үзүүлж, 5 албан хаагчдад 10 өдрийн цалинтай чөлөө 1,500,000 төгрөгний тэтгэмж олгосон.
11.	2.7	Албан хаагчид сар бүр унаа, хоолны мөнгөн олговрыг тооцож олгох;	Тухай бүр	Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.4 дэх заалтад хамаарах албан хаагчид	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Албан хаагчдад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих болон өдрийн хоолны хөнгөлөлтийн хэмжээг зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан байгууллагын төсөвт багтаан жил бүр Газрын даргын тушаалаар тогтоож, Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем”-д бүртгэн, сар бүр ажилласан хоногт нь тооцон олгосон.
12.	2.8	Албан хаагчдыг ажлын зайлшгүй шаардлагаар долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр илүү цагаар ажиллуулсан бол албан хаагчийг ажлын өдөр нөхөн	Жилдээ	Засгийн газрын 2028 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.8 дэх заалтад	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар Цагаан сарын баярын өдрүүдэд 10 албан хаагч, 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар Үндэсний их баяр наадмын өдрүүдэд 16 албан хаагч, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/446 дугаар тушаалаар “Шинэ жил”-ийн баярын өдрүүдэд 2 албан хаагчдыг хариуцлагатай

		амруулах эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдүүлсэн цалин хөлс олгох;		хамаарах албан хаагчид				жижүүрээр ажиллуулж, ажлын өдөр нөхөн амруулсан.
13.	2.9	Төрийн албан хаагчид өвлийн улирлын бэлтгэлээ хангахад зориулж нөхөн төлбөр олгох;	III-р улирал	Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.5.4 дэх заалтад хамаарах албан хаагчид	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Өвөлжилтийн бэлтгэлээ хангахад зориулж 2 албан хаагчдад түлшний зардалд зориулан 500,000 төгрөгний нөхөх төлбөр олгосон.
14.	2.10	Агентлагийн албан хаагчдад зуслангийн зориулалтаар олгосон газарт тохижилт, дэд бүтэц, төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;	II-р улирал	Тухайн байгууллагын санал, санаачилгын хүрээнд зохион байгуулах;	Агентлагийн зуслангийн газартай албан хаагчидтай хамтран зохион байгуулах;	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	2025.05.30-ны өдөр 1/1951 дүгээр албан бичгээр Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д байгууллагын албан хаагчдын зуслангийн газар болох ХУД-ын 14-р хороо Ар хөндлөнгийн аманд байршдаг айл өрхүүд цахилгааны техникийн нөхцөл авахаар хүсэлт хүргүүлж 2025.06.26-ны өдрийн 01/02897/25 дугаар техникийн нөхцөл батлагдаж, зураг төслийн ажил гүйцэтгэж байгаа болно.
15.	2.11	Албан хаагч эрхэлсэн ажил мэргэжлийнхээ дагуу оюуны бүтээл туурвихад байгууллагын зүгээс эх бэлтгэх, хэвлэх, олшруулах, олон нийтэд сурталчлах зэрэгт дэмжлэг үзүүлэх;	Жилдээ	Хууль тогтоомжид нийцсэн дэмжлэг үзүүлсэн байна.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	ГЗБГЗЗЕГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр хурлаар “Дундын мэдээллийн сан”- гийн эцсийн үр дүнг хэлэлцэж тус системийг хүлээн авч, хэрэглээнд нэвтрүүлэн Оюуны өмчийн газарт бүртгүүлэх шийдвэр гарсан. Хурлын шийдвэрийн дагуу Оюуны өмчийн газарт 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1/1525 дугаартай албан бичгээр тус системд зохиогчийн эрх авах тухай хүсэлт гаргасан. Оюуны өмчийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/54 дугаар тушаалаар №16766 дугаарт бүртгэж, гэрчилгээ олгосон.
16.	2.12	Албан хаагчдыг хөдөлмөрийн эрүүл	Жилдээ	Албан томилолтоор ажилладаг албан	Агентлагийн албан хаагчдыг	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Албан хаагчдыг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлаар хангах зорилгоор 6

		ахуй, аюулгүй байдлаар хангах зорилгоор хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах;		хаагчийг хувцас хэрэгслээр хангасан байна.	хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах			ширхэг 1,533,600 төгрөгийн өмд, хүрэм, 6 ширхэг 255,600 төгрөгийн малгай-г хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, нийт хангалтын өртөг 1,789,200 төгрөг болсон.
17.	2.13	Албан хаагчдын шагнал, урамшуулал, нийгмийн асуудал шийдвэрлэсэн асуудлын нэгдсэн судалгаа гаргаж, хүний нөөцийн системд мэдээллийг нэмэх;	Жилдээ	Судалгаа гарсан, хүний нөөцийн системд тусгагдсан байна.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Салбарыг хөгжүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган ажилласан 2 албан хаагчийг “Төрийн албан тэргүүний ажилтан” тэмдгээр, 20 албан хаагчийг “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр, 61 албан хаагчийг Ерөнхий газрын даргын “Жуух бичиг”-ээр, 1 албан хаагчийг “Хилийн төлөө” медаль тэмдгээр шагнасан бөгөөд эдгээр албан хаагчдын мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем”-д бүртгэсэн.
18.	2.14	Албан хаагчдаас ажлын байрны орчин нөхцөлийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авах;	Жилдээ	Судалгааны агуулга, хэлбэрийг жишиг загварт нийцүүлэн боловсруулж, нийт албан хаагчдын 80-аас доошгүй хувийг хамруулсан байна.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	21 аймгийн ГХБХБГ-ын албан хаагчдаас ажлын байрны орчин нөхцөлийн талаар сэтгэл ханамж, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй судалгаагаар компьютер техник хэрэгслийн 18 хувь нь сүүлийн 3 жилд худалдан авч ашиглаж байгаа, 82 хувь нь ашиглалтын хугацаа дууссан шинэчлэх шаардлагатай гарсан. 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх, төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор 238 сумын газрын даамлын 185 иж бүрэн компьютер, 26 сканнер, 30 принтерийг нийт 765.2 сая төгрөгөөр, 4 аймгийн Геодезийн хэмжилтийн багажийг 128.0 сая төгрөгөөр, 20 аймгийн 170 сумын газрын даамлын 130 архивын шүүгээ, 37 ширээ, 57 сандал нийт 157.0 сая төгрөгөөр тус тус бүрэн шинэчилсэн.

19.	2.15	Албан хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг тогтоож, ажлын байранд англи хэлний сургалт зохион байгуулах;	Жилдээ	Албан хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлсэн байна.	Агентлагийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Нийт албан хаагчдаас Англи хэлний сургалтанд хамрагдах сонирхол болон хэлний түвшний судалгааг авч, үр дүнг нэгтгэн удирдлагад танилцуулсан. Байгууллагын Англи хэлний сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд руу албан бичиг хүргүүлж үнийн саналыг авсан. Байгууллагын төсөв, албан хаагчдын цагийн хуваарийг харгалзан үзэж цахим, уян хатан, хүн бүрийн түвшинд тохирсон Англи хэлний уншлагын хөтөлбөр болох Read Theory-г байгууллагын хэмжээнд нэвтрүүлээд байна. Албан хаагчдын ахицын тайланг долоо хоногийн даваа гараг бүр нийтэлж байгаа бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 2-ны байдлаар 33 албан хаагчид элсээд байна.
20.	2.16	Албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр бариулсан орон сууцыг ашиглалтанд хүлээн авах ажилд захиалагчийн зүгээс хяналт тавих;	Жилдээ	Барилгын ажлын явц 1 орц баригдаж ашиглалтад хүлээн авахад бэлэн болсон.	Албан хаагчид орон сууцанд орсон байна.	Гүйцэтгэгч компани болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;	Агентлаг	Албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр бариулсан орон сууцны хоёрдугаар блок ашиглалтанд орж, албан хаагчид байраа хүлээн авч орсон.
Гурав: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилтын хүрээнд”								
21.	3.1	Албан хаагчдын ажиллах нөхцөл, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа хангах, өрөө тасалгааг тохижуулах;	Жилдээ	Төрийн албаны тухай хуулийн 55.3 дахь заалт, ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах;	Ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, ажиллах орчинг тохижуулах зорилгоор сургалтын өрөө болон байгууллагын 3 хэлтсийн өрөөг тохижуулсан. Энэ ажлын нийт өртөг 25,8 сая төгрөгийг бүрдүүлсэн бөгөөд тохижилтод шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, дотоод засал чимэглэл зэрэгт зарцуулсан.
22.	3.2	Албан хаагчдын компьютер, багаж,	Жилдээ	Төрийн албаны тухай хуулийн 55.3 дахь заалт,	Ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ажиллах	Агентлагийн нийт албан хаагчид	Агентлаг	136 ширхэг компьютер, принтер, ухаалаг таблет, геодезийн багаж, хөргөлтийн төхөөрөмж, дрон, цаас уртасгагч, зөөврийн

		тоног төхөөрөмжийг шинэчлэх;		хэрэгцээ, шаардлага, өнөөгийн байдлыг тооцож төсвийн тооцоог гаргасан байх;	нөхцөлийг сайжруулсан байна.			компьютер, хурдан сканнер, сервер тоног төхөөрөмжийг 2,093,700 төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр худалж авч, шинэчилсэн.
Дөрөв: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд								
23.	4.1	Албан хаагчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд хамруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;	Жилдээ	Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 9.3 дахь хэсэгт заасны дагуу нийт албан хаагчдыг хамруулна.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байна.	Нийт албан хаагчид	Агентлаг	2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 2024/358 дугаартай ‘Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийх гэрээ’-г Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй байгуулж, нийт 12,120,000 төгрөгийн өртгөөр 93 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 2025 оны 01 дүгээр сард бүрэн хамруулсан.
24.	4.2	Албан хаагчдын сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах аливаа өвчлөлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх;	Улирал бүр	Мэргэжлийн сэтгэл зүйн сургалт, судалгаа, оношилгоо, зөвлөгөө авсан байна.	Мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авч ажлын бүтээмж, манлайлал, урам зориг нэмэгдсэн байна.	Нийт албан хаагчид	Агентлаг	-
25.	4.3	Албан хаагчдын эрүүл мэнд, эрүүл амьдрах, дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор “Эцэг эхийн зөвлөл”, “Эмэгтэйчүүдийн зөвлөл”, “Соёл спорт, эрүүл мэндийн зөвлөл”-өөс тэмцээн уралдаан зохион байгуулах;	Жилдээ	Хөдөлмөрийн бүтээлч хандлага, гэр бүлийн эв нэгдэл, эрүүл мэнд сайжирч, санал санаачилгыг өрнүүлсэн байна.	Хөдөлмөрийн бүтээлч хандлага, гэр бүлийн эв нэгдэл, эрүүл мэнд сайжирсан байна.	Нийт албан хаагчид	Агентлаг	Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, хамт олны дунд нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2025/29 дүгээр гэрээгээр “Новел” спорт заалтай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Уг гэрээний хүрээнд албан хаагчдыг тогтмол спортын үйл ажиллагаанд хамруулж, 7 хоног бүрийн Мягмар гарагт спорт зааланд биеийн тамир, чийрэгжүүлэх дасгал хөдөлгөөнд хамрагдаж байна.

Тав: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Албан хаагчдын сонирхол, хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагад нийцүүлж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилтын хүрээнд”

26.	5.1	Байгууллага, хамт олны дунд найрсаг, бие биеэ хүндэтгэсэн орчин, албан хаагчдын зөв харилцаа, хандлага, соёлыг төлөвшүүлэх, сайн туршлагыг дэмжих, дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	Жилдээ	Залуу албан хаагчдын санал санаачилгыг дэмжиж, төрийн үйлчилгээнд шинэ арга барил, хэв шинжийг нэвтрүүлсэн байна.	Залуу албан хаагчдын санал санаачилгыг дэмжиж, төрийн үйлчилгээнд шинэ арга барил, хэв шинжийг нэвтрүүлсэн байна.	Нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Аз жаргалтай гэр бүл” сэдэвт сургалт болон “Газрын харилцааны салбарын хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Лектор О.Жаргалсайхан сургалтын хүрээнд хувь хүний манлайлал, нийгэм дэх эмэгтэйчүүдийн оролцоо, харилцааны дүрэм, толины хууль зэрэг сэдвүүдээр оролцогчдод мэдлэг, мэдээлэл өгч, албан хаагчдын урам зоригийг нэмэгдүүлсэн.
27.	5.2	Байгууллага, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий “Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл” ажиллах бөгөөд байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх спорт, урлагийн арга хэмжээг зохион байгуулах;	Жилдээ	Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 9.8 дэх хэсэгт заасны дагуу нийт албан хаагчдыг хамруулна.	Нийтээр тэмдэглэх баяр ёслол, тэмдэглэлт ой, ажилтнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлсэн байна.	Нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 10 дугаар сарын 24–25-ны өдрүүдэд шилжин явах цомын төлөө спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, албан хаагчдын дунд биеийн тамир, спортын идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх дадал хэвшлийг төлөвшүүлэх, хамт олны нөхөрсөг харилцаа, эв нэгдлийг бэхжүүлэх, мөн багаар ажиллах ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан.
Зургаа: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Албан хаагчийн гэр бүлийг дэмжих зорилтын хүрээнд”								
28.	6.1	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах;	I-р улирал	“Эмэгтэйчүүдийн зөвлөл”, “Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл”-ийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг зохион байгуулах;	Нийт эмэгтэйчүүд хамрагдсан байна.	Нийт албан хаагчид	Агентлаг	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өдрийг тохиолдуулан эмэгтэй албан хаагчдад цахим мэндчилгээг хүргэсэн.
29.	6.2	Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдаас	II-р улирал	Одонтой албан хаагчдад хүндэтгэл үзүүлэх;	Одонтой албан хаагчид	Нийт албан хаагчид	Агентлаг	2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/202 дугаар тушаалаар Эх үрсийн баярын арга хэмжээг зохион байгуулж, албан

		одонтой ээжүүдэд зориулсан арга хэмжээг зохион байгуулах;						хаагчдын 127 хүүхдэд бэлэг гардуулан, 5 одонтой эхэд хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулсан.
30.	6.3	Байгууллагын туслах аж ахуйгаас мал, мах өгөх ажлыг зохион байгуулах;	2 удаа	Малын тоо, толгойноос хамааран дэмжлэг үзүүлсэн байна.	Туслах аж ахуйн малчинтай хамтран зохион байгуулах;	Нийт албан хаагчид	Агентлаг	2024 оны 10 дугаар сарын 020ны өдөр байгууллагын туслах аж ахуйгаас 2 албан хаагчийн дунд 1 бог мал олгосон.
31.	6.4	ГЗБГЗЗЕГ-ын төрийн албан хаагчдад хөдөө аж ахуйн зориулалтаар газар олгуулах асуудлыг Газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд судалж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;	Жилдээ	Газрын гэрчилгээг гардуулсан байна.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх.	Нийт албан хаагчид	Агентлаг, Төв аймгийн ГХБХБГ-тай хамтран ажиллах	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй.

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР